



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/28

Шивээговь сум

Сэг зэм устгалын ажил
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/52 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сэг зэм устгалын ажлыг хавар, намрын улиралд зохион байгуулсугай.

2.Сэг зэм устгалын ажил зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Маналмаа
(2 дугаар багийн Засаг дарга)

Гишүүд:

С.Отгонбаатар
(1 дүгээр багийн Засаг дарга)
Д.Эрдэнэтулга
(Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Мөнхзаяа
(Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

О.Отгонбаяр
(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

3.Сэг зэм устгалын ажлыг хаврын улиралд зохион байгуулахад зарцуулагдах зардлын төсвийг 1 дүгээр хавсралтаар, намрын улиралд зохион байгуулахад зарцуулагдах зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Сэг зэм устгалын ажилд зарцуулагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг сумын “Байгаль хамгаалах, орчны бохирдлыг бууруулах-хоггүй сум” арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

5.Ажлыг чанартай зохион байгуулж, үр дүнг гарган танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Д.Маналмаа), захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын ...-ны ...р
сарын ...-ний өдрийн ... дугаар
захирамжийн ...-р хавсралт



**СУМЫН “БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ – ХОГГУЙ СУМ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД
ХАВРЫН УЛИРАЛД СЭГ ЗЭМ УСТГАЛЫН АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ**

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ/төг/	Нийт үнэ /төг/	
Төв хогийн цэгийн хог хаягдлыг цэвэрлэх түрж, булшлах ажил	Шатахуун	Дизель	4000	440000	
		АИ-92	2560	128000	
	Тээвэр	Ажлын хөлс	2 өдөр	150000	300000
		Хоол	2 өдөр	121000	242000
	Ажлын хувцас	Нэг удаагийн хувцас	6 ширхэг	25000	150000
		Бээлий	6 ш	5000	30000
		Маск	1 боодол	10000	10000
	Туслах ажилтны хөлс	Цалин	2 хүн	50000	200000
			Нийт		

Төсөв гаргасан:

Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн **О.Отгонбаяр**

